



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/150

Хархорин сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.12, Засгийн газрын 2019 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2 дугаар багийн иргэн Дарамбазарын Бямбын мал 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдөр орсон аадар бороонд урсаж хорогдсон тул үнэлгээ тогтоох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Солонго (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Гишүүдэд:

Р.Сүхбат (2 дугаар багийн Засаг дарга)

Ц.Баатарсүрэн (Байгаль орчны асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Н.Төгөлдөр (Байгаль хамгаалагч)

Нарийн бичгийн дарга: Н.Отгонбаяр (Нярав)

2.Үнэлгээг зах зээлийн үнэлгээтэй уялдуулан үнэлж, тайланг харьяалах онцгой байдлын байгууллагад хүргүүлэхийг ажлын хэсэг (Ж.Солонго)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

101100299